



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 1/21

Шивээговь сум

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
 бэлэн байдлын зэргийг цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 66 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 02 дугаар Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын “Шар түвшин”-д шилжүүлэх тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/52 дугаар “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг цуцлах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хэмжээнд гамшгаас хамгаалах “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэн хугацааг 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн цуцалж, Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын “Шар түвшин”-д шилжүүлсүгэй.

2. Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, мэргэжлийн байгууллагаас өгч буй заавар, зөвлөмжийг биелүүлж, зохион байгуулахыг төр хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад, хариу арга хэмжээ, тандалт, эмнэлгийн тусламж үйлчилгээнд тасалдал, доголдол үүсэх хариуцлага хяналт сулрах зэрэг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Сувданцэцэг)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ